



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/26.

Арвайхээр сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хархорин сумын нэгдсэн эмнэлэгт 2023 онд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: М.Нинжбадгар (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)

Гишүүд: Н.Отгонбаяр (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн)

Э.Баярсайхан (Хархорин сумын Нэгдсэн эмнэлгийн эм зүйч)

М.Лхагвасүрэн (Хархорин сумын Нэгдсэн эмнэлгийн мэс заслын эмч)

Б.Ууганбаяр (Иргэний төлөөлөл)


Г.Гантөмөр (Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга: М.Мөнхнаран (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хорооны дарга (М.Нинжбадгар)-д даалгасугай.

3.Төндөр шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (М.Мөнхнаран)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0053

D:My Doc. Zahiramj. Zasag darga